

**ТҮШИГ-УУЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫНТЭМДЭГЛЭЛ**

2021 онь 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатархот

ХЭЛЭЛЦСЭННЬ:

“ТҮШИГ УУЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14.00цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо, Жуулчины гудамж, Монгол Тайваны төв 2 давхарт 207 тоотод болов.

Хуралд : Ж.Баяраа 830800 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Б,Үүрийннцолмон 17031 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Ж.Батсайхан 869 120 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр /

Л.Ганчимэг 868 030 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

2584981 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 59.4 % хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ж.Баяраа удирдав.

Хурлаар:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
2. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
3. Бусад асуудлыг тус тус хэлэлцэв.

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Г.Алтаймаа ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 59.4 % хувьтай байгаа тул Монголын Улсын компанийн тухай хуулийн 69.1 д заасаны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэв.

Хурал 14.20 минутанд эхлэв.

СОНССОН НЬ :

ТУЗ-ийн дарга Ж.Баяраа: Бид компаний 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцахын чацуу цаашдын үйл ажиллагааны талаар хэлэлцэнэ. Ингээд та бүхнийг хуралдаа идэвхтэй оролцохыг хүсэж байна.

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг / Гүйцэтгэх захирал Ж.Батсайхан танилцуулав /
2. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг /ерөнхий нягтлан танилцуулав /

СОНССОН НЬ 1:

Ж.Батсайхан /ТүшигУул ХК-ийн захирал/

Компаний үйл ажиллагаа 2020 он 2 сарын 25 наас 10 хүний бүрэлдэхүүнтэй засварын ажил 5 сарын 1 хүртэл 2 сар гаруй хугацаанд шугамын турба солих, насосны ажлын дугуй , цамц солих ,цахилгааны засвар үйлчилгээ шинэчлэлт хийх зэрэг бусад ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Дээрхи ажлуудыг хийхэд гарсан зардлуудыг үйл ажиллагааны тайлан дээр тодорхой тусгасан байгаа. Манай компаний ачилт арчилгаа үйлчилгээ хийж байгаа төмөр зам нь 6,4 км урттай ойролцоогоор таван зуу гаруй үетэй 11730 гаруй дэр мод байдаг. Жилд дор хаяж 20 хувь дэр мод солих шаардлагатай гэж үзвэл 2345 ширхэг дэр модны хэрэгцээ байна. 2020 онд бид төмөр замын тусгай зөвшөөрөлтэй "Тайван Хайрхан" ХХК тай жилийн 60 гаруй сая төгрөгний зам арчлалтын гэрээ байгуулан 1000 гаруй дэр мод, дүнг солиж засвар үйлчилгээ хийлгэсэн.

Борлуулалтын үйл ажиллагааны талаар: Компани нь 2020 онд Дархан-Уул аймгийн барилгын компаниуд Стандарт стийль , Их торгоны зам , Ганхүдэр орд ХХК, Цагаан зуун ХХК, Мөнх од цацрал ХХК , Бурхант хясаат ХХК , Зуурмагын үзэлүүдэд мөн орхон аймгийн "РСЦ" ХХК, "ОТК" ХХК, "Шилэн цамхаг" ХХК төмөр замын байгууллага болох ХБДҮ, ЗХ БАҮ 1-р анги болон бусад компаниудад бүтээгдэхүүнээ нийлүүлсэн.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт нэмэгдүүлэхэд дараахи хүндрэлүүд гарч байна. Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд олон жил болж хуучирсан учир эвдрэл саатал гарч цаг хугацаа их зарцуулагдаж байна. "УБТЗ"-н вагоны хүрэлцээ хангамж муу байгаагаас захиалгат бүтээгдэхүүний борлуулалт хугацаа хоцрох тасалдах зэрэг асуудал гарч байна. 2020 онд цахилгаан эрчим хүч, төмөр замын тээвэр, болон зах зээл дээр зарагдаж буй материал сэлбэгүүдийн үнэ өссөнөөр бүтээгдэхүүний өртөг өсөхөд нөлөөлж байна.

Төмөр зам ашиглалтын үйлчилгээ. Төмөр замын байгууллага нь өндөр шаардлага тавьдаг. Автотээвэр хийснээс хамаагүй бага зардал тусдаг. Төмөр замд түрүү жилд их хөрөнгө оруулалт хийсэн. Хувийн компанитай харилцаж 8-9 сая төгрөгийг өгч байгаа. Яг төмөр зам нь өндөр өртөгтэй.

Улаанбаатар ТЗ 20% үнээ нэмсэн. Үнэ нэмэгдсэнээс компаниудтай хийсэн гэрээ тал хагас болсон. 7 сард тогны мөнгө нэмэгдсэнээр бидний зардал бас нөлөөлсөн. Барилгын компаниуд төлбөр тооцоо хийх байдал нь багасч өр авлага ихтэй болсон.

Ж.Баяраа /Хувьцаа эзэмшигч/

1982-1984 онд үйл ажиллагаанд оруулсан. Гол зүйл жемснаряд. Усанд дээр явдаг энэ төхөөрөмж маань 20-25 жил болдог. Манай жемснаряднь 30-35 жил болсон зэврэлт шүүрэлт ихтэй болсон. Дараа зун гэхэд усанд живэх магадлалтай. Үүнийг засаж янзлах мэргэжлийн хүн байхгүй хөрөнгө мөнгө байхгүй. Энэ бас томоохон асуудал болж байна. Төмөр замын арчилгааны ажил бас хүндрэлтэй болсон. Р50 олон улсын стандартын шаардлага хангахгүй. Бетон дэрний нэг ширхэг нь 200 мянга байдаг. Үндсэндээ нэг км төмөр зам барихад 1 тэрбумаас-1,5 тэрбум орно гэдэг асар хүндрэлтэй болж байна. Төмөр замынхан хүчээр л ачаа явуулаад байдаг. Энэ байдлаараа явахын бол энэ компани дампуурах гээд байна. Үүнийг санхүүжүүлэх гэдэг зүйл байхгүй. Уг нь бол тухайн орны засаг нь хөрөнгө оруулалтаа хийдэг байтал манай энэ байдал олон компани уруудах шалтгаан болж байна. Энэ асуудал би олон арван хөрөнгө оруулалт хийсэн. Энэ үйлдвэр маань үнэхээрийн үеэ өнгөрөөж байна. Гол юм орд газар. Ер нь гол зардал төмөр зам аваад байдаг машин тээвэр хийе гэхээр төмөр замаасаа илүү зардал гардаг. Ирээдүйтэй компани гэхээр бас хэлж болохгүй ирээдүйгүй гэхээр зах зээл маань төмөр зам маань асуудал үүсгэдэг. Олон улсын бүхий л стандартад өндөрлөсөн салаа төмөр зам байдаг. Үүнтэй ижил төрлөөр бид хөрөнгө оруулалт хийж оргилуун сэтгэлээр авч яваад байдаг.

Нэмэлт хувьцаа гаргая гэсэн санал гаргасан. Эрдэнэт үйлдвэрт бид нийлүүлэх гээд 2 хүн ОХУ-д сургасан. Гангын хэвний үйлдвэр, шилний үйлдвэр байгуулна гэсэн дэврүүн сэтгэлээр явсан. Хойшоо явсан шинжилгээний хариунд ийм газрын орд газрын элс болохгүй байна. Гэсэн хариу ирсэн.

Ингээд цаашид нэмэлт хувьцаа гаргаж болохгүй, нэр өөрчилж болохгүй боллоо. Бид илэн далангүй ярилцах цаг боллоо. МУ-д бол ХК-ний жишгээр зөв эрүүл санхүүжилт хийж явна. Элсний төсөл маань ингээд зогслоо. Уул уурхай гэхээр хэд хэдэн лиценз байна. 1000-д лиценз монгол олгосон. Гэвч энэ нь хууль бус ар өврийн хаалгаар олгогдсон. Цаашид сайхан цаг ирэх байх. Миний хувьд нас ахиж байна. Залуу байсан шигээ явъя гэхээр нийгэм болоод ард иргэдээ бодохгүй төр засагтай. Цаашид энэ компаниа ийм чигээр нь байлгахуу яах вэ гэдэг миний бодол болж байна. Геологи уул уурхай, барилга барилгын материалаараа мэргэшсэн энэ компанийг удирдаад аваад явах хүн хүн байна уу, лидерүүд байхгүй болцон. Тэгэхээр цаашид энэ бидний хөрөнгө, монголын ард түмний хөрөнгө болохоор бүгдээрээ илэн далангүй ярилцаж ямар нэгэн төсөл компаниа чиглэсэн бодлого байна уу, эсвэл нэг хэсэг зогсоохуу. Жемснаряд маань усандаа живэх аюултай болсон, төмөр замын хувьд иймэрхүү байдаг. м2 нь 2000-3000 төгрөгийн ашигтай ажиллаж энэ маань бидэнд хуримтлал болохгүй ажилчдын цалин, нийгмийн даатгалд өртэй болоод дарамтанд буцаад орж байна. Үйлдвэрлэгчдийн зовлон иймэрхүү байдагийг ойлгож байна. Би 1995 онд анх 400 саяар авч байсан. Үүний оронд банк байгуулах маань яав гэж бодож эхэлж байна. Шинжлэх ухааны ийм том институтээ бас нураачмааргүй. Эдийн засгийн үр ашигтай компани ажилчдад ашигтай төслийг 2 гараа өргөөд дэмжихэд бэлэн байна.

Энэ уул уурхай гэдэг дээр томчуудын гар хөл болоод томчууд оролцдог юм байна. Бидэнд өнөөдөр хуваагаад авах мөнгө алга, цаашид компаний хувь заяагаа яах вэ, земснарядыг засъя гэхээр хөрөнгө мөнгө болохгүй ОХУ-ын мэргэжилтэнгүүд 100 мянган доллароор засаж өгье гэсэн. Бидэнд байхгүй.

Б.Үүрийнцолмон /Хувьцаа эзэмшигч/

Жемснарядыг даатгалд хамруулсануу?

Ж.Баяраа /Хувьцаа эзэмшигч/

Даатгуулаагүй.

Ж.Батсайхан /Түшиг-Уул ХК-ийн захирал/

Даатгалын компани даатгаж авдаггүй. Айдаг байх. Баруун тал нь живхээн шахаж байсан бид энэ үед ярихад даатгалын компани авах гүйлгэдэг юм байна лээ. Гадаад компани юу юм бэ гэхээс. Монголын компани даатгаж авдаггүй.

Ж.Баяраа /Хувьцаа эзэмшигч/

1995 онд би асар их буруу үйл ажиллагаа явуулжээ. Олон сая төгрөг салхинд хийсгэж үүний оронд ломбард байгуулсан бол яахуу. Би бол уг нь энэ том зүйлийг өдийг хүртэл авч явсандаа бахархдаг. Монголын ард түмэнд би бол өрөө төлсөн гэж боддог энэ том салбарт биеэ зориулж, гэвч өөрийнхөө хөрөнгийг бодохоор бас хэцүү. Би түүхэнд бол том зүйлийг хийжээ л гэж дүгнэж байна. Нарны зам, Оюутолгой, нисэх онгоцны буудал зэрэг томоохон байгууламжуудад бидний энэ ажил оролцсон. Стандартуудыг нь батлуулж ойлгоуулах гэж зөндөө явсан. Мэддэг чаддаг хүн Монголд алга. Хувьцаа эзэмшигчдийг том жижиг гэлгүй гомдоолгүй яаж авч явахуу, эсүл 51%-ийг БНХАУ-ын компани өгье гэвэл бид ярилцах зүйл их байна, эсвэл үгүйээ бид хятад дургүй Монголынхоо ирээдүйг бодъё гэх үү компаниа цаашид яах вэ.

Санхүүгийн мөнгөний савлагаа маш их байгаа учир энэ савлагааг даах хүн байна уу, Монголын залуучууд мэдлэг муутай боловсон хүчин, төлөвшлийн асуудал байна. Монголчууд том зорилгоосоо ухарч байна. Төр нь шинжлэх ухааны институтэд анхаарлаа хандуулаагүй. Цаашид энэ хэдэн хүүхдүүддээ асуудал үлдээгээд яах вээ. Том лиценз авчихаар бас нэлээн том зүйл болж шоронгийн хоригдолч болж болох байна. Хувьцаат компаний тогтолцоо олон сая төгрөгөөр арилждаг Монголд ийм тогтолцоо байхгүй. Монголын хувь заяанд илэн далангүй хэлэхэд итгэл муутай байна. Хэдэн хүүхдүүддээ ял өгмөөргүй байна. Бид компаний засаглалыг мэдэх хүмүүс юуг нь нуух вэ сайхан ярилцъя. Би өөрийгөө хүртэл голж байна. Хөрөнгө оруулагч нарыг

Татъя гэхээр дундах хүмүүс нь хулхидаад эдийн засгийн дампууралд орцон байна. Хувьцаа эзэмшигч нар эвтэй байж цаашид яах талаар сайн ярилцъя.

Нягтлан бодогч: Ноогдол ашиг хувиарлах, хувиарлахгүй тухай шийдвэр гаргадаг эцсийн субъект нь ТУЗ байдаг. Компанийн тухай хуулийн 46.5 заасны дагуу эцсийн шийдвэрийг гаргадаг. ТУЗ уг шийдвэрийг хувьцаа эзэмшигчидийн хуралд мэдээлэх үүрэг хүлээдэг.

Хурлын дарга: Асуух зүйл байна уу.

Байхгүй бол саналаа өгөөд хурлаа завсарлах уу.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:1

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2020 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулсаныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 15 цаг 30 минутанд өндөрлөв.

ХУРЛЫНДАРГА

/Ж.БАЯРАА/

ТЭМДЭГЛЭЛХӨТӨЛСӨН

/А.АРИУНСАЙН/

